

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
УИХ	Улсын Их Хурал
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба



АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧ Ж.АМАРЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/222
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн.

Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Ж.Амаржаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2019 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Пийк Ом Аудит ХХК-ийн аудитор Б.Наранчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Пийк Ом Аудит ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01/75 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Алтанбулаг чөлөөт бүсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Алтанбулаг чөлөөт бүс нь эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

“Чөлөөт бүсийн тухай хууль”-д Алтанбулаг чөлөөт бүсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах;
- Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох;
- Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах, эрүүл мэндийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу олгох

Алтанбулаг чөлөөт бүсийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Алтанбулаг чөлөөт бүсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Чөлөөт бүсийн тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Алтанбулаг чөлөөт бүсийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Алтанбулаг чөлөөт бүс санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “CTS” програм хангамж ашигладаг байна.

Алтанбулаг чөлөөт бүсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Алтанбулаг чөлөөт бүсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 1.0 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус байгууллагын орлогын 81.7 хувийг улсын төсвийн санхүүжилт эзэлдэг, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний явцад өндөр өртөгтэй хөрөнгийн үнэ цэнэ буурсан, үр дүнгийн тайланд тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зардал бодитоор илэрхийлэгддэг зэрэгтэй холбоотой юм.

Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,120,022.7 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 51,200.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 5 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	362,402.5	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	5,035.4	
3	Албан шаардлага өгсөн	2	369,031.4	
	Дүн	3	736,469.3	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрч акт, албан шаардлага тавигдсан болон залруулсан алдааны дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Төсвийн зардлын гүйцэтгэлийн талаар:

1. Чөлөөт бүсийн захирагч, Захирагчийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч нарт давхардуулан 4,239.4 мянган төгрөгийг, Аж ахуйн үйлчилгээ, ашиглалтын тасгийн даргад 795.9 мянган төгрөг нийт 5,035.4 мянган төгрөгийн урамшууллыг олгосон нь Сангийн сайдын 2006 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 292 дугаар тушаалаар батлагдсан Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам"-ын 2.1 дэх " Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын ерөнхий менежер нь ... тухайн аж ахуйн нэгж, байгууллагын **нягтлан бодох бүртгэлийн ажилтны** ажлыг дүгнэсэн шийдвэр гаргаж байгууллагын нөөц бололцоонд тулгуурлан нь улирал бүр шагнаж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Балансын урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох;

2. Цагийн бүртгэл, нотлох баримтгүйгээр ажилтнуудад 19,152.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөх;

3. Ажилтнуудын төрийн алба хаасан хугацаа, зэрэг дэв, цалингийн шатлал ахиулж нэмэгдэл хөлсөнд 6,977.1 мянган төгрөгийг олгосон нь УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 5 дугаар зүйл "Төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсөв захирагч нарт даалгах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөх;

4. Тайлант онд аудитын ажлын хөлс, авто тээврийн хэрэгслийн татвар, авто замын хураамж, жолоочийн даатгалын хураамж, өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчийн тэтгэмж зэрэг нийт 30,753.6 мянган төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т "Төсвийн байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын "Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын зардал бүлгийн 3.2, 3.10-д заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв;

5. Засварын ажлын хөлс 172.0 мянган төгрөгийг сэлбэгийн зардлаар, 1,010.0 мянган төгрөгийн шатахууныг албан томилолтын зардлаар тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв;

6. Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 1,188.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын зардлаар тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 6-р зүйлийн 6.11-д “Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зарлага хэсэгт ...үндсэн хөрөнгө худалдан авах, олж бэлтгэхэд...зарцуулсан зардлыг харуулна” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

Үндсэн хөрөнгийн талаар:

1. Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 285,451.3 мянган төгрөгийн өртөгтэй зураг төсвийг барилга нь ашиглалтанд орсон боловч өртөгт шингээх бичилт хийгээгүйгээс жилийн эцэст үлдэгдлээр бүртгэсэн нь УСНББОУС-17 -ийн 89 (в), Сангийн сайд 2006 оны 388 дугаар тушаалын холбогдох заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

Авлагын талаар:

1. Өмнөх оны аудитаар газар эзэмших эрх нь цуцлагдсан 55 компаний 756,798.0 мянган төгрөгийн газрын төлбөрийн авлагыг барагдуулах албан шаардлага өгсөн боловч 14 компаний 329,461.7 мянган төгрөгийн авлагын нэхэмжлэлийг шаардлага хангасан нотлох баримтгүй шалтгаанаар шүүх нэхэмжлэлийг буцаасан, мөн анхан шатны шүүхээс төлүүлэхээр шийдвэр гарсан 13,440.0 мянган төгрөгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд хандаагүй зэргээр нийт 342,901.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.6.1 дэх “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө эсхүл дээд шатныхаа төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага барагдуулах ажлыг зохион байгуулах, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй асуудлууд байна. Үүнд:

Катя, Скайтрейдинг, Алтанбулагийн хөгжил ХХК-аас 199,658.0 мянган төгрөгийн авлагыг тус компаниудын газар эзэмших гэрээ байхгүй шалтгаанаар шүүхэд нэхэмжлэл гаргах боломжгүй нөхцөл үүсжээ.

Цаашид дээрх авлагыг барагдуулах асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Алтанбулаг чөлөөт бүсийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 610,119.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 592,562.8 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь урсгал зардлын хэмнэлтээс шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Алтанбулаг чөлөөт бүс Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Алтанбулаг чөлөөт бүс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр ил тод мэдээлж ажилласан байна. Үүнд:

- Батлагдсан төсөв /бүтэн жилээр/
- Дараа жилийн төсвийн төсөл /бүтэн жилээр/
- Санхүүгийн тайлан /хагас, бүтэн жилээр/
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /бүтэн жилээр/
- Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан /бүтэн жилээр/
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /бүтэн жил, хагас жил, улирал, сар бүр/
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /тухай бүр/
- Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт /тухай бүр/

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Алтанбулаг чөлөөт бүсийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлагын талаар:

1.1. Илрүүлэлт:

Анхан шатны шүүх 33 аж ахуйн нэгжийн 362,402.5 мянган төгрөгийн авлагыг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэсэн боловч харьяалах дээд шатны байгууллагын шийдвэр гаргуулж асуудлыг шийдвэрлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.6.1 дэх “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө эсхүл дээд шатныхаа төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Энэ нь “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна насжилт ихтэй авлага бий болох эрсдэлийг үүсгэж байна.

1.3. Өгсөн зөвлөмж:

Шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болсон дээрх авлагыг 2019 оны 2-р улиралд багтаан авлагын данснаас хасах арга хэмжээ авах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2019 оны 07 сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,254,489,630.96	1,313,177,853.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	117,908,185.00	125,938,585.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	117,908,185.00	125,938,585.00
3121	Төгрөг	117,908,185.00	125,938,585.00
31211	Төрийн сангийн харилцах	117,908,185.00	125,938,585.00
33	АВЛАГА	1,126,143,294.32	1,177,086,554.12
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	19,754.20	-
335	Бусад авлага	1,126,123,540.12	1,177,086,554.12
3351	Байгууллагаас авах авлага	1,126,123,540.12	1,177,086,554.12
35	БАРАА МАТЕРИАЛ	10,438,151.64	10,152,713.97
354	Хангамжийн материал	10,438,151.64	10,152,713.97
35410	Бичиг хэргийн материал	1,170,500.00	345,300.00
35440	Түлш, шатах тослох материал	387,977.49	35,850.82
35470	Бусад хангамжийн материал	8,879,674.15	9,771,563.15
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	23,700,217,382.98	24,193,075,727.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	23,700,217,382.98	24,193,075,727.34
392	Биет хөрөнгө	22,819,019,881.04	19,059,789,360.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	24,095,796,978.96	18,937,197,627.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,682,533,993.25	-566,086,495.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,000,000.00	23,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,895,304.00	-23,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	57,187,807.12	387,804,621.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	-43,163,320.29	-84,098,395.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,053,044.85	85,053,044.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	-51,491,297.35	-57,147,008.12
39216	Дуусаагүй барилга, байгууламж	357,065,965.00	357,065,965.00
393	Биет бус хөрөнгө	881,197,501.94	5,133,286,366.74
39301	Програм хангамж	2,500,000.00	2,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,233,333.30	-1,633,333.26
39303	Бусад биет бус хөрөнгө	1,210,068,335.00	5,430,982,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-330,137,499.76	-298,562,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	24,954,707,013.94	25,506,253,580.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	111,448,518.00	73,579,658.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	111,448,518.00	73,579,658.50
413	Өглөг	98,848,518.00	73,579,658.50
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	79,700,058.00	72,200,058.00
4136	Бусад өглөг	19,148,460.00	1,379,600.50
41361	Байгууллагад төлөх өглөг	19,148,460.00	1,379,600.50
414	Урьдчилж орсон орлого	12,600,000.00	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	12,600,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,843,258,495.94	25,432,673,921.93
51	Засгийн газрын хувь оролцоо	24,843,258,495.94	25,432,673,921.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,954,938,118.00	6,542,753,318.00
51101	Өмч: - төрийн	1,954,938,118.00	6,542,753,318.00
512	Хуримтлагдсан үр дүн	22,850,797,749.49	18,568,839,640.99
51210	Өмнөх үеийн үр дүн	22,940,235,278.64	22,856,223,460.08
51220	Тайлант үеийн үр дүн	-89,437,529.15	-4,287,383,819.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	37,522,628.45	321,080,962.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,954,707,013.94	25,506,253,580.43

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	952,861,102.00	832,638,883.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	143,936,754.00	151,626,560.00
120	Нийтлэг татварын бус орлого	143,936,754.00	151,626,560.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	127,856,754.00	136,411,560.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	125,627,058.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	136,411,560.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,229,696.00	0.00
120009	Бусад орлого	16,080,000.00	15,215,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	808,924,348.00	681,012,323.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	235,478,648.00	681,012,323.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	610,119,500.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	235,478,648.00	0.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	0.00	70,892,823.00
1330	Төсвийн захирагчдаас	573,445,700.00	0.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	573,445,700.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,040,355,297.63	1,693,455,017.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,040,355,297.63	1,693,455,017.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	859,897,139.53	1,522,718,918.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,170,210.45	359,146,088.01
210101	Үндсэн цалин	288,429,045.45	331,059,088.01
210102	Нэмэгдэл	46,272,165.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,469,000.00	28,087,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,226,743.98	43,170,795.50
210201	Тэтгэврийн даатгал	25,505,889.39	29,443,294.61
210202	Тэтгэмжийн даатгал	3,451,643.00	3,677,942.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,953,014.62	2,871,314.03
210204	Ажилгүйдлийн даатгал	663,148.07	661,577.81
210205	Эрүүл мэндийн даатгал	6,653,048.90	6,516,666.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,726,151.00	57,198,186.00
210301	Гэрэл, цахилгаан	47,411,608.00	51,782,361.00
210302	Түлш, халаалт	2,946,771.00	1,655,825.00
210303	Цэвэр, бохир ус	367,772.00	3,760,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,851,024.34	11,596,720.67
210401	Бичиг хэрэг	2,595,500.00	3,543,567.50
210402	Тээвэр, шатахуун	5,443,435.04	5,435,926.67
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,836,399.30	2,417,226.50
210404	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,775,690.00	0.00

Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,769,700.00	13,828,296.00
210604	Урсгал засвар	11,769,700.00	13,828,296.00
2107	Томилолт, зочны зардал	7,525,797.00	8,067,216.00
210702	Дотоод албан томилолт	7,525,797.00	8,067,216.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,232,572.20	58,531,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,269,800.00	49,521,030.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	356,400.00	312,390.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	395,700.00	191,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,500.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,920,800.00	2,344,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	120,000.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,145,372.20	2,161,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	341,394,940.56	971,180,496.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	660,000.00	750,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	340,734,940.56	970,430,496.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	180,458,158.10	170,736,099.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,323,000.00	26,463,863.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,323,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	26,463,863.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	168,135,158.10	144,272,236.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	168,135,158.10	144,272,236.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-87,494,195.63	-860,816,134.41
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,943,333.52	3,426,567,684.68
225003	Хөрөнгө оруулалтын гарз	1,943,333.52	0.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	0.00	3,426,567,684.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,943,333.52	-3,426,567,684.68
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-89,437,529.15	-4,287,383,819.09

4.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	861,865,460.00	744,865,409.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,941,112.00	63,853,086.00
120	Нийтлэг татварын бус орлого	52,941,112.00	63,853,086.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	61,238,086.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	61,238,086.00
120009	Бусад орлого	52,941,112.00	2,615,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	808,924,348.00	681,012,323.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	808,924,348.00	681,012,323.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	573,445,700.00	610,119,500.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	235,478,648.00	0.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	0.00	70,892,823.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	703,385,152.46	735,647,009.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	703,385,152.46	735,647,009.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	522,926,994.36	564,910,909.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,981,599.50	359,698,500.90
210101	Үндсэн цалин	303,444,999.50	286,271,000.90
210102	Нэмэгдэл	32,067,600.00	45,300,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,469,000.00	28,126,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,246,498.10	42,598,628.41
210201	Тэтгэврийн даатгал	19,915,638.12	31,835,265.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,822,920.47	2,751,986.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,123,331.11	2,491,800.89
210204	Ажилгүйдлийн даатгал	671,328.26	912,894.53
210205	Эрүүл мэндийн даатгал	6,713,280.14	4,606,681.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,726,151.00	57,198,186.00
210301	Гэрэл, цахилгаан	47,411,608.00	51,782,361.00
210302	Түлш, халаалт	2,946,771.00	1,655,825.00
210303	Цэвэр, бохир ус	367,772.00	3,760,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,194,608.76	10,065,973.50
210401	Бичиг хэрэг	2,292,100.00	2,364,947.00
210402	Тээвэр, шатахуун	5,090,419.46	5,083,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,836,399.30	2,417,226.50
210404	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,775,690.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,925,140.00	14,216,296.00
210604	Урсгал засвар	13,925,140.00	14,216,296.00
2107	Томилолт, зочны зардал	7,525,797.00	8,067,216.00
210702	Дотоод албан томилолт	7,525,797.00	8,067,216.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,667,200.00	59,388,429.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,269,800.00	50,411,819.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	356,400.00	312,390.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	395,700.00	191,700.00

Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,500.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,145,800.00	1,958,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	165,000.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,310,000.00	2,514,520.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	660,000.00	13,677,680.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	12,927,680.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	660,000.00	750,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	180,458,158.10	170,736,099.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,323,000.00	26,463,863.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,323,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	26,463,863.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	168,135,158.10	144,272,236.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	168,135,158.10	144,272,236.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	158,480,307.54	9,218,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	158,488,827.00	1,188,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	158,488,827.00	1,188,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	158,488,827.00	0.00
220001	Барилга байгууламж	158,488,827.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-158,488,827.00	-1,188,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-8,519.46	8,030,400.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	117,916,704.46	117,908,185.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	117,908,185.00	125,938,585.00

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,954,938,118.00	37,522,628.45	22,940,235,278.64	24,932,696,025.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,954,938,118.00	37,522,628.45	22,940,235,278.64	24,932,696,025.09
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-89,437,529.15	-89,437,529.15
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,954,938,118.00	37,522,628.45	22,850,797,749.49	24,843,258,495.94
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,954,938,118.00	37,522,628.45	22,850,797,749.49	24,843,258,495.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	5,425,710.59	5,425,710.59
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,954,938,118.00	37,522,628.45	22,856,223,460.08	24,848,684,206.53
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	283,558,334.49	0.00	283,558,334.49
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	4,587,815,200.00	0.00	0.00	4,587,815,200.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-4,287,383,819.09	-4,287,383,819.09
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,542,753,318.00	321,080,962.94	18,568,839,640.99	25,432,673,921.93

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	610,119,500.00	592,562,772.81	17,556,727.19	97.12
3	УРСГАЛ ЗАРДАЛ	610,119,500.00	591,374,772.81	18,744,727.19	96.93
4	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	569,648,200.00	564,910,909.81	4,737,290.19	99.17
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,185,900.00	359,698,500.90	19,487,399.10	94.86
6	Үндсэн цалин	298,666,800.00	286,271,000.90	12,395,799.10	95.85
7	Нэмэгдэл	45,300,800.00	45,300,800.00	-	100
8	Унаа хоолны хөнгөлөлт	35,218,300.00	28,126,700.00	7,091,600.00	79.86
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,502,400.00	42,598,628.41	2,903,771.59	93.62
10	Тэтгэврийн даатгал	30,334,900.00	31,835,265.00	-1,500,365.00	104.95
11	Тэтгэмжийн даатгал	3,791,900.00	2,751,986.31	1,039,913.69	72.58
12	ҮОМШӨ-ний даатгал	3,033,500.00	2,491,800.89	541,699.11	82.14
13	Ажилгүйдлийн даатгал	758,400.00	912,894.53	-154,494.53	120.37
14	Эрүүл мэндийн даатгал	7,583,700.00	4,606,681.68	2,977,018.32	60.74
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,272,000.00	57,198,186.00	10,073,814.00	85.03
16	Гэрэл, цахилгаан	55,890,800.00	51,782,361.00	4,108,439.00	92.65
17	Түлш, халаалт	7,128,000.00	1,655,825.00	5,472,175.00	23.23
18	Цэвэр, бохир ус	4,253,200.00	3,760,000.00	493,200.00	88.4
19	Хангамж, бараа материалын зардал	10,714,700.00	10,065,973.50	648,726.50	93.95
20	Бичиг хэрэг	2,367,800.00	2,364,947.00	2,853.00	99.88
21	Тээвэр, шатахуун	5,083,800.00	5,083,800.00	-	100
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,063,100.00	2,417,226.50	645,873.50	78.91
23	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00	-	100
24	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	-	-
25	Нормативт зардал	-	-	-	-
26	Эд хогшил, урсгал засварын зардал	14,228,700.00	14,216,296.00	12,404.00	99.91
27	Урсгал засвар	14,228,700.00	14,216,296.00	12,404.00	99.91
28	Томилолт, зочны зардал	2,929,500.00	8,067,216.00	-5,137,716.00	275.38
29	Дотоод албан томилолт	2,929,500.00	8,067,216.00	-5,137,716.00	275.38
30	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,040,800.00	59,388,429.00	-10,347,629.00	121.1
31	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,060,900.00	50,081,819.00	-13,020,919.00	135.13
32	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	-	100
33	Даатгалын үйлчилгээ	356,400.00	312,390.00	44,010.00	87.65
34	Тээврийн хэрэгслийн татвар	538,600.00	191,700.00	346,900.00	35.59

Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

35	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,700.00	-	32,700.00	-
36	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,150,100.00	2,288,000.00	862,100.00	72.63
37	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,384,100.00	-	1,384,100.00	-
38	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,518,000.00	2,514,520.00	3,480.00	99.86
39	Бараа үйлчилгээний бусад зардал	774,200.00	13,677,680.00	-12,903,480.00	1,766.69
40	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,927,680.00	-12,927,680.00	-
41	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	774,200.00	750,000.00	24,200.00	96.87
42	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,471,300.00	26,463,863.00	14,007,437.00	65.39
43	Бусад урсгал шилжүүлэг	40,471,300.00	26,463,863.00	14,007,437.00	65.39
44	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-	-	-
45	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,700,000.00	-	8,700,000.00	-
46	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,771,300.00	26,463,863.00	5,307,437.00	83.29
47	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	-
48	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	-
49	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,188,000.00	-1,188,000.00	-
50	Дотоод эх үүсвэрээр	-	1,188,000.00	-1,188,000.00	-
51	Барилга байгууламж	-	-	-	-
52	Тоног төхөөрөмж	-	1,188,000.00	-1,188,000.00	-
53	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	744,865,409.00	-744,865,409.00	-
54	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	681,012,323.00	-681,012,323.00	-
55	Улсын төсвөөс санхүүжих	-	610,119,500.00	-610,119,500.00	-
56	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	-
57	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	-
58	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-	-	-
59	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	61,238,086.00	-61,238,086.00	-
60	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	61,238,086.00	-61,238,086.00	-
61	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
62	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	117,908,185.00	-117,908,185.00	-
63	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	125,938,585.00	-125,938,585.00	-
64	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
65	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
66	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42	35	-	-

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.25	Аудитын нэр: Алтанбулаг чөлөөт бүсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит.	Аудитын код: САГ-2019/192/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Алтанбулаг чөлөөт бүс	мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуулла гаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Алтанбулаг чөлөөт бүсийн захирагч, Захирагчийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч нарт давхардуулан мөн Аж ахуйн үйлчилгээ, ашиглалтын тасгийн даргад балансын урамшуулал олгосон.	5,035.4	төлбөрийн акт	Захирагч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Амаржаргал Г.Балцэцэг
2	Ажилтнуудын төрийн алба хаасан хугацаа, зэрэг дэв, цалингийн шатлал ахиулж нэмэгдэл хөлс олгосон	19,152.6	албан шаардлага	Захирагч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Амаржаргал Г.Балцэцэг
3	Цагийн бүртгэл, нотлох баримтгүйгээр ажилтнуудад илүү цагийн хөлс олгосон	6,977.1	албан шаардлага	Захирагч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Амаржаргал Г.Балцэцэг
4	Өмнөх оны аудитаар газар эзэмших эрх нь цуцлагдсан 55 компаний 756,798.0 мянган төгрөгийн газрын төлбөрийн авлагыг барагдуулах албан шаардлага өгсөн боловч 14 компаний 329,461.7 мянган төгрөгийн авлагын нэхэмжлэлийг шаардлага хангасан нотлох баримтгүй шалтгаанаар шүүх нэхэмжлэлийг буцаасан, мөн анхан шатны шүүхээс төлүүлэхээр шийдвэр гарсан 13,440.0 мянган төгрөгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд хандаагүй зэргээр нийт 342,901.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй	342,901.7	албан шаардлага	Захирагч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Амаржаргал Г.Балцэцэг
5	Анхан шатны шүүх 33 аж ахуйн нэгжийн авлагыг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэсэн боловч харъяалах дээд шатны байгууллагын шийдвэр гаргуулж асуудлыг шийдвэрлээгүй	362,402.5	зөвлөмж	Захирагч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Амаржаргал Г.Балцэцэг
	Дүн	736,469.3			

